



СПОРТЫН БЭЛТГЭЛИЙН ТӨВ
ЗАХИРАЛ Б.НАРАНБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.09 № 3/19 ЧАТ-САТ/2014/131/СТНТА-011 243

Улсын төсвийн орлого
төвлөрүүлэх тухай

Спортын бэлтгэлийн төвийн 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Спорт сургалтын төвийн захирлын 2013 оны 9 сарын 3-ны өдрийн 468 тоот тушаалаар “Сургалт, судалгааны төсөл хэрэгжүүлэх тухай” “Спортын шинжлэх ухаанаас суралцахуй сэдэв”-т төслийг хэрэгжүүлэхээр 67,378,400 төгрөгийн дотоод томилолтын зардлыг биеийн тамирын уралдаан тэмцээний зардлаас гаргахдаа 6 ажилтанд 3,317,024 төгрөгийг баримтгүйгээр олгосон зөрчил илэрлээ.

Томилолтын зардлын тооцоо, тайланг гаргахдаа баримтын бүрдэл дутуу томилолтоор явсан хүн бүрээр томилолтын хуудсыг бичиж баталгаажуулаагүй нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дах заалт, 7 дугаар зүйлийн 7.7 дах заалт, мөн “Төсвийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дах “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчсөн байна.

Иймд “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалт “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...” гэснийг, Ерөнхий аудиторовын 2009 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 47-р тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Спортын шинжлэх ухаанаас суралцахуй сэдэв”-т төслийг хэрэгжүүлэхээр олгосон дотоод томилолтын зардлын 3,317,024 төгрөгийг баримтын бүрдэлгүй, томилолтын хуудасгүй олгосон тул Төрийн сан дахь улсын төсвийн 900000601 тоот дансанд 2014 оны 5 дугаар сарын 1-ний дотор төвлөрүүлэх
2. Тогтоосон хугацаанд төлбөрийг барагдуулж биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Спорт бэлтгэлийн төвийн захирал Б.Наранбаатар, ерөнхий нягтлан бодогч Б.Туяа нарт хариуцуулав.



Акт. албан шаардлага-А4 бланк

071154